



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 8 сарын 12 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу барилгын салбарын шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүр шалгаруулж, нийтэд мэдээлж ажиллахыг байнгын комисс /С.Магнайсүрэн/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 136 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

  
Х.БАДЕЛХАН



08 00434

Барилга, хот байгуулалтын сайдын  
2019 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн  
140 дугаар тушаалын хавсралт

## БАРИЛГЫН САЛБАРЫН ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи ашиглан зураг төсөл боловсруулсан, хот байгуулалтын оновчтой шийдэл гаргасан, шинэ дэвшилтэт материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, барилга байгууламжийг өндөр үзүүлэлттэй барьж ашиглалтад оруулсан, ашиглалтыг хариуцан явуулж байгаа, шинэ техник, технологи нэвтрүүлсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчил дутагдалгүй ажиллаж, амжилт гаргасан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын амжилтыг үнэлж урамшуулан, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд таниулан, мэдээлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Барилгын болон нийтийн аж ахуйн салбарт тусгай зөвшөөрлийн дагуу ажил, үйлчилгээ эрхэлж тухайн онд, үр бүтээлтэй ажилласан, шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулж, сурталчлахад энэ журмыг мөрдөнө.

1.3. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар томилогдсон байнгын комисс нь болзлыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүрийн 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор оны шилдэгт нэр дэвшиж буй аж ахуйн нэгжүүдийн ажлын тайлан, үйл ажиллагааны үр дүн үзүүлэлт, мэргэжлийн хяналтын байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоодын мэдээлэл, санал дүгнэлтийг үндэслэн шалгаруулна.

1.4. Оны шилдэгт нэр дэвших шалгуур хангасан аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн ажлын чиглэлээр 2 жилийн дотор дахин нэр дэвшихгүй байх, харин бусад чиглэлээр жил бүр нэр дэвшиж болно.

1.5. Комисс нь шалгуур хангасан аж ахуйн нэгж, байгууллагын материалыг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор шалгаруулна.

1.6. Оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагааны дараах үндсэн чиглэлээр шалгаруулна.

1.6.1. барилга угсралтын (3);

1.6.2. инженерийн шугам сүлжээний (1);

1.6.3. барилгын материал үйлдвэрлэлийн (2);

1.6.4. хот байгуулалтын баримт бичиг, гадна тохижилт, инженер геологи, барилга байгууламжийн зураг төслийн (2);

1.6.5. өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний (1);

1.6.6. нийтийн аж ахуйн (1);

1.6.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (1).

1.7. Энэ журамд заасан шалгуурыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагууд тухайн оныхоо ажлын үзүүлэлтийг гаргаж жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-т битүүмжлэн хүргүүлнэ.

1.8. Шалгаруулалтад орох аж ахуйн нэгж, байгууллага нь хүсэлтээ албан бичгээр ирүүлэх ба хүсэлт ирүүлээгүй буюу хугацаа хоцроож ирүүлсэн бол шалгаруулалтад оруулахгүй.

### **Хоёр. Тавигдах шаардлага, нөхцөл**

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжийн тухайн оны ажлын үр дүн үзүүлэлтийг дараах шалгуураар дүгнэнэ. Үүнд:

#### **2.1.1.Барилга угсралтын чиглэлээр:**

2.1.1.1.Тухайн онд ашиглалтад оруулсан барилга байгууламж угсралт, засварын ажлын тоо, төсөвт өртөг /Сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.1.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /Сүүлийн 2 жил/, /8 хүртэл оноо/;

2.1.1.3.Нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилчдыг тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /8 хүртэл оноо/;

2.1.1.4.Тухайн жилийн нормчлолын сангийн шимтгэл төлсөн байдал /баримт/, /5 хүртэл оноо/;

2.1.1.5.Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах, /8 хүртэл оноо/;

2.1.1.6.Инженер техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.1.7.Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи, нэвтрүүлсэн ашигласан байдал, дотоодын барилгын материалын бүтээгдэхүүнийг барилгын ажилд хэрэглэсэн байдал, /8 хүртэл оноо/;

2.1.1.8.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /10 хүртэл оноо/;

2.1.1.9.Байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал, /10 хүртэл оноо/.

#### **2.1.2.Инженерийн шугам сүлжээний чиглэлээр:**

2.1.2.1.Тухайн онд ашиглалтад оруулсан барилга байгууламжийн шугам сүлжээний угсралт, засварын ажлын тоо, төсөвт өртөг /Сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.2.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /Сүүлийн 2 жил/, /8 хүртэл оноо/;

2.1.2.3.Нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилчдыг тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /8 хүртэл оноо/;

2.1.2.4.Тухайн жилийн нормчлолын сангийн шимтгэл төлсөн байдал /баримт/, /5 хүртэл оноо/;

2.1.2.5.Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах, /8 хүртэл оноо/;

2.1.2.6.Инженер техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.2.7.Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи, нэвтрүүлсэн ашигласан байдал, дотоодын барилгын материалын бүтээгдэхүүнийг барилгын ажилд хэрэглэсэн байдал, /8 хүртэл оноо/;

2.1.2.8.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /10 хүртэл оноо/;

2.1.2.9.Байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал, /10 хүртэл оноо/.

### **2.1.3.Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр:**

2.1.3.1.Тухайн онд нийт үйлдвэрлэж борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, Стандартын шаардлагад нийцүүлэн тохирлын гэрчилгээ авсан бүтээгдэхүүний нэр төрөл; /10 хүртэл оноо/

2.1.3.2.Тоног төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадлын ашиглалт 50%-иас доошгүй байх, /10 хүртэл оноо/;

2.1.3.3.Нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилчдыг тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.3.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.3.5.Үйлдвэрлэлд дахивар материал ашигласан байдал /5 хүртэл оноо/;

2.1.3.6.Мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал /5 хүртэл оноо/;

2.1.3.7.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /8 хүртэл оноо/;

2.1.3.8.Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах, /8 хүртэл оноо/;

2.1.3.9. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал, /10 хүртэл оноо/.

**2.1.4. Хот байгуулалтын баримт бичиг, гадна тохижилт, инженер геологи, барилга байгууламжийн зураг төслийн чиглэлээр:**

2.1.4.1. Тухайн онд гүйцэтгэсэн хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламж, инженер геологийн зураг төслийн ажлын үнийн дүн /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.4.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.4.3. Нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилчдыг тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.4.4. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах/, /8 хүртэл оноо/;

2.1.4.5. Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи, цахим тооцоолуур нэвтрүүлсэн ашигласан байдал, норм дүрмийн дагуу зөрчилгүй зураг төсөл боловсруулсан байдал, /8 хүртэл оноо/;

2.1.4.6. Инженер техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.4.7. Зохиосон зураг төслөөс улсын экспертизээр хянагдсан тоо, илэрсэн зөрчил, дутагдал, /8 хүртэл оноо/;

2.1.4.8. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал, /10 хүртэл оноо/.

**2.1.4 Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний чиглэлээр:**

2.1.5.1. Тухайн онд гүйцэтгэсэн, үйлдвэрлэл, засвар, угсралтын ажлын хэмжээ, төсөвт өртөг /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жил/, /10 хүртэл оноо/;

2.1.5.3. Нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилчдыг тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.5.4. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол /хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагаас авсан тодорхойлолтыг хавсаргах/, /8 хүртэл оноо/;

2.1.5.5. Инженер техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.5.6. Шинэ дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй техник технологи, нэвтрүүлсэн ашигласан байдал, /8 хүртэл оноо/;

2.1.5.7. Тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн байдал, /8 хүртэл оноо/;

2.1.5.8.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /8 хүртэл оноо/.

#### **2.1.6.Нийтийн аж ахуйн чиглэлээр:**

2.1.6.1.Нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ зэрэг үзүүлэлт /хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, захиалагч байгууллагуудаас авсан тодорхойлолтыг хавсаргах/, ажил үйлчилгээг иргэдэд тодорхой ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал /8 хүртэл оноо/;

2.1.6.2.Нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилчдыг тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /10 хүртэл оноо/;

2.1.6.3.Инженер техникийн ажилтан болон ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал, /8 хүртэл оноо/;

2.1.6.4.Онцгой ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөр, шинэ дэвшилтэт материал, техник технологи нэвтрүүлсэн бүтээл нь бодит эдийн засгийн үр ашиг гаргасан байдал, /8 хүртэл оноо/;

2.1.6.5.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /8 хүртэл оноо/;

2.1.6.6.Байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал, /10 хүртэл оноо/.

#### **2.1.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр:**

2.1.7.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /Сүүлийн 2 жил/, /8 хүртэл оноо/;

2.1.7.2.Нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажилчдыг тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцлөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байдал, зарцуулсан зардал /сая төгрөг/, /8 хүртэл оноо/;

2.1.7.3.Барилга байгууламжийн угсралтын үед гарсан осол, гэмтэл хэрэглэгчийн санал гомдолын талаарх мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс авсан тодорхойлолтыг хавсаргах, /10 хүртэл оноо/;

2.1.7.4.Тухайн жилийн нормчлолын сангийн шимтгэл төлсөн байдал /баримт/, /5 хүртэл оноо/;

2.1.7.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, Инженер техникийн ажилтан, нийт ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан хүний тоо, зарцуулсан зардал /8 хүртэл оноо/;

2.1.7.6.Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй эсэх. /8 хүртэл оноо/;

2.1.7.7. Байгууллагын ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал, /8 хүртэл оноо/;

2.1.7.8. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй ажилласан байдал, зарцуулсан зардал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /10 хүртэл оноо/;

2.1.7.9. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны /ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 гэх мэт/ стандартыг нэвтрүүлэх талаар дэвшил гаргасан байдал, /10 хүртэл оноо/.

2.2. Тухайн оны ажлын хүрээг урд оны 7 дугаар сарын 1-ээс тухайн оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл тогтооно.

### **Гурав. Комиссын хуралдаан**

3.1. Хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг комиссын нарийн бичгийн дарга хариуцна.

3.2. Хурлаар хэлэлцүүлэх шалгаруулалтын материалыг чиглэл тус бүрийн мэргэжлийн холбоод болон холбогдох байгууллагуудад хүргүүлж урьдчилсан санал авах.

3.3. Чиглэл тус бүрийн мэргэжлийн холбоод болон холбогдох байгууллагуудын саналыг үндсэн шалгуур үзүүлэлт болгон авч үзнэ.

3.4. Хурлаар хэлэлцүүлэх шалгаруулалтын материалыг комиссын даргад танилцуулан хурлын товыг гаргаж гишүүдэд 2 хоногийн өмнө мэдэгдсэн байна.

3.5. Хуралд гишүүдийн 3-ны 2 нь ирснээр хүчинтэй байх бөгөөд гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй бол хуралдаан эхлэхээс өмнө мэдэгдэж өөрийн саналыг бичгээр ирүүлнэ.

3.6. Комиссын хуралд гишүүнээр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцох боломжгүй тохиолдолд комиссын хуралдаан товлогдсон өдрөөс 2 хоногийн өмнө ажлын хэсгийн бүрэлдэхүүнд албан бичгээр хандана.

3.7. Аж ахуйн нэгж бүрийн шалгаруулалтад ирүүлсэн материалд гишүүд тус бүр оноо өгч, хуралд оролцсон гишүүдийн өгсөн онооны нийлбэр дүнгээр дүгнэнэ. Нийт үнэлгээний 80% нь гишүүдийн оноо байх ба үлдсэн 20% нь чиглэл тус бүрийн мэргэжлийн холбоод болон холбогдох байгууллагуудаас ирсэн саналд тулгуурлана.

3.8. Шалгаруулалтын комисс нь хуралдааны тэмдэглэл, шийдвэрийг архивын тухай хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэн "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын архивт хүлээлгэн өгнө.

### **Дөрөв. Баталгаажуулах**

4.1. Ирүүлсэн материалыг тушаалын 2 дугаар хавсралтад заасан байнгын комисс шалгаруулж дүнг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталгаажуулна.

4.2. Шалгаруулах комиссын гишүүдэд нөлөөлөх, комиссын гаргасан шийдвэрийг өөрчлөхийг хориглоно

4.3. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталгаажин салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагаар шалгарсан байгууллагад барилгын

асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажлын 2 хоногийн дотор мэдэгдэнэ.

#### **Тав. Шагнал урамшуулал**

5.1.Оны шилдэг байгууллагаар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагад Барилга, хот байгуулалтын сайдын гарын үсэгтэй цом хадгалуулж, туг мандуулах эрхийг жил бүрийн 9 дүгээр сарын эхний 7 хоногт болдог Барилгачдын өдөр гардуулж, аж ахуйн нэгжийн лого бүхий тугийг барилгачдын талбайд байрлуулан хүндэтгэлийн тавцанд жилийн турш мандуулна.

5.2.Шалгарсан байгууллагуудын товч танилцуулга, ажлын амжилт, туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж сурталчилна.

5.3.Барилгачдын өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд барилгын салбарын оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллагад шагнал гардуулах үйл ажиллагааг барилгачдын талбай дээр зохион байгуулна.

#### **Зургаа. Бусад**

6.1.Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагын мандуулах туг 1:2 харьцаатай /босоо 1м\*хэвтээ 2м/ гурван ширхэг байна.

6.2.Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага нь улирал тутам өөрийн тугийг сольж байх үүрэгтэй.

----oOo----



“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын нэгдүгээр хавсралт

## БАРИЛГЫН САЛБАРЫН ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд: Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Дэд бүтцийн хяналтын газрын дарга

“Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-ын төлөөлөл

“Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо” ТББ-ын төлөөлөл

“Өргөн тээвэрлэх машин төхөөрөмж үндэсний холбоо” ТББ-ын төлөөлөл

“Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ-ын төлөөлөл

“Монголын архитекторуудын эвлэл” ТББ-ын төлөөлөл

“Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын төлөөлөл

“Барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-ын төлөөлөл

“Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын төлөөлөл

“Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” ТББ-ын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн асуудал хариуцсан нэгжийн дарга

“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын хоёрдугаар хавсралт

### БАРИЛГА УГСРАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ МАЯГТ-1

- 2.1. Аж ахуйн нэгжийн нэр:
- 2.2. Регистр:
- 2.3. Тусгай зөвшөөрлийн дугаар:
- 2.4. Ашиглалтад оруулсан ажлын тоо, төсөвт өртөг /сая төгрөг/:
- 2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жилд/:
- 2.6. Нормчлолын санд төлсөн шимтгэл /сүүлийн 2 жилийн дүнг мянган төгрөгөөр/:
- 2.7. Ажлын байр нэмэгдүүлсэн тоо /тухайн онд/:
- 2.8. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол:
- 2.9. Нийгмийн халамжийн хүрээнд зарцуулсан зардал /сая төгрөг/:
- 2.10. Ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулсан байдал зарцуулсан зардал /сая төгрөг/:

№	Сургалтад хамруулсан ажилчдын тоо	Зарцуулсан зардал /сая төгрөг/

- 2.11. Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлсэн ашигласан байдал:
- 2.12. Дотоодын барилгын материалын бүтээгдэхүүнийг барилгын ажилд хэрэглэсэн байдал:
- 2.13. ХАБЭА-д зарцуулсан зардал /сая төгрөг/:
- 2.14. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн чанарын удирдлагын тогтолцоо /нэр, дугаараар/:
- 2.15. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

..... (.....)  
Тэмдэг      Гарын үсэг      Нэр

20... оны ..... сарын .....-ны өдөр

---oOo---

“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын гуравдугаар хавсралт

**ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ШАЛГАРУУЛАЛТАД  
ОРОЛЦОХ МАЯГТ-2**

- 2.16. Аж ахуйн нэгжийн нэр:  
2.17. Регистр:  
2.18. Тусгай зөвшөөрлийн дугаар:  
2.19. Ашиглалтад оруулсан ажлын тоо, төсөвт өртөг /сая төгрөг/:  
2.20. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жилд/:  
2.21. Нормчлолын санд төлсөн шимтгэл /сүүлийн 2 жилийн дүнг мянган төгрөгөөр/:  
2.22. Ажлын байр нэмэгдүүлсэн тоо /тухайн онд/:  
2.23. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол:  
2.24. Нийгмийн халамжийн хүрээнд зарцуулсан зардал /сая төгрөг/:  
2.25. Ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулсан байдал зарцуулсан зардал /сая төгрөг/:

№	Сургалтад хамруулсан ажилчдын тоо	Зарцуулсан зардал /сая төгрөг/

- 2.26. Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлсэн ашигласан байдал:  
2.27. Дотоодын барилгын материалын бүтээгдэхүүнийг барилгын ажилд хэрэглэсэн байдал:  
2.28. ХАБЭА-д зарцуулсан зардал /сая төгрөг/:  
2.29. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн чанарын удирдлагын тогтолцоо /нэр, дугаараар/:  
2.30. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

..... (.....)  
Тэмдэг      Гарын үсэг      Нэр

20... оны ..... сарын .....-ны өдөр

---oOo---

“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын дөрөвдүгээр хавсралт

### БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ МАЯГТ-3

1. Аж ахуйн нэгжийн нэр:
2. Регистр:
3. Тусгай зөвшөөрлийн дугаар:
4. Тухайн онд үйлдвэрийн хүч чадлын ашиглалтын хувь, борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ:
5. Тохирлын гэрчилгээ авсан бүтээгдэхүүний тоо хэмжээ:
6. Үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын хувь, борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ:
7. Мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулсан байдал:
8. Үйлдвэрлэлд дахивар материал ашигласан байдал:
9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жилд/:
10. Ажлын байр нэмэгдүүлсэн тоо /тухайн онд/:
11. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол:
12. Нийгмийн халамжийн хүрээнд зарцуулсан зардал /сая төгрөг/:
13. Ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулсан байдал зарцуулсан зардал /сая төгрөг/:

№	Сургалтад хамруулсан ажилчдын тоо	Зарцуулсан зардал /сая төгрөг/

14. Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлсэн ашигласан байдал:
15. ХАБЭА-д зарцуулсан зардал /сая төгрөг/:
16. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн чанарын удирдлагын тогтолцоо /нэр, дугаараар/:
17. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

..... (.....)  
Тэмдэг      Гарын үсэг      Нэр

20... оны ..... сарын .....-ны өдөр

---oO---

“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын тавдугаар хавсралт

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ, ГАДНА ТОХИЖИЛТ, ИНЖЕНЕР  
ГЕОЛОГИ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ЧИГЛЭЛЭЭР  
ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ МАЯГТ-4**

1. Аж ахуйн нэгжийн нэр:
2. Регистр:
3. Тусгай зөвшөөрлийн дугаар:
4. Тухайн онд гүйцэтгэсэн хот байгуулалтын баримт бичиг, инженер геологи, барилга байгууламжийн зураг төслийн ажлын үнийн дүн /сая төгрөг/:
5. Үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын хувь, борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ:
6. Зохиосон зураг төслөөс улсын экспертизээр хянагдсан тоо, илэрсэн зөрчил дутагдал:
7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жилд/:
8. Ажлын байр нэмэгдүүлсэн тоо /тухайн онд/:
9. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол:
10. Нийгмийн халамжийн хүрээнд зарцуулсан зардал /сая төгрөг/:
11. Ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулсан байдал зарцуулсан зардал /сая төгрөг/:

№	Сургалтад хамруулсан ажилчдын тоо	Зарцуулсан зардал /сая төгрөг/

12. Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлсэн ашигласан байдал:
13. Норм дүрмийн дагуу зураг төсөл боловсруулсан байдал:
14. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн чанарын удирдлагын тогтолцоо /нэр, дугаараар/:
15. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

..... (.....)  
Тэмдэг      Гарын үсэг      Нэр

20... оны ..... сарын .....-ны өдөр

“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын зургаадугаар хавсралт

**ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,  
УГСРАЛТ, ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР  
ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ МАЯГТ-5**

1. Аж ахуйн нэгжийн нэр:
2. Регистр:
3. Тусгай зөвшөөрлийн дугаар:
4. Гүйцэтгэсэн, үйлдвэрлэл, засвар, угсралтын ажлын хэмжээ, төсөвт өртөг /сая төгрөг/:
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жилд/:
6. Нормчлолын санд төлсөн шимтгэл /сүүлийн 2 жилийн дүнг мянган төгрөгөөр/
7. Ажлын байр нэмэгдүүлсэн тоо /тухайн онд/:
8. Хэрэглэгчийн сэтгэл ханамж, санал гомдол:
9. Нийгмийн халамжийн хүрээнд зарцуулсан зардал /сая төгрөг/:
10. Ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулсан байдал зарцуулсан зардал /сая төгрөг/:

№	Сургалтад хамруулсан ажилчдын тоо	Зарцуулсан зардал /сая төгрөг/

11. Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлсэн ашигласан байдал:
12. Тоног төхөөрөмжийн шинэчлэлийн байдал:
13. ХАБЭА-д зарцуулсан зардал /сая төгрөг/:
14. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн чанарын удирдлагын тогтолцоо /нэр, дугаараар/:
15. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

..... (.....)  
Тэмдэг      Гарын үсэг      Нэр

20... оны ..... сарын .....-ны өдөр

“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын долоодугаар хавсралт

**НИЙТИЙН АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР  
ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ МАЯГТ-6**

1. Аж ахуйн нэгжийн нэр:
2. Регистр:
3. Нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ зэрэг үзүүлэлт, ажил үйлчилгээг иргэдэд тодорхой ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал:
4. Ажлын байр нэмэгдүүлсэн тоо /тухайн онд/:
5. Нийгмийн халамжийн хүрээнд зарцуулсан зардал /сая төгрөг/:
6. Ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулсан байдал зарцуулсан зардал /сая төгрөг/:

№	Сургалтад хамруулсан ажилчдын тоо	Зарцуулсан зардал /сая төгрөг/

7. Онцгой ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөр, шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлсэн, бүтээл нь бодит эдийн засгийн үр ашиг гаргасан байдал:
8. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн чанарын удирдлагын тогтолцоо /нэр, дугаараар/:
9. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

..... (.....)  
Тэмдэг      Гарын үсэг      Нэр

20... оны ..... сарын .....-ны өдөр

----oo0oo----

“Барилгын салбарын оны шилдэг  
аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах  
журам”-ын наймдугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР  
ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ МАЯГТ-7**

1. Аж ахуйн нэгжийн нэр:
2. Регистр:
3. Тусгай зөвшөөрлийн дугаар:
4. Ашиглалтад оруулсан ажлын тоо, төсөвт өртөг /сая төгрөг/:
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн биелэлт, мэдээ, тайлан ирүүлсэн байдал /сүүлийн 2 жилд/:
6. Нормчлолын санд төлсөн шимтгэл /сүүлийн 2 жилийн дүнг мянган төгрөгөөр/:
7. Ажлын байр нэмэгдүүлсэн тоо /тухайн онд/:
8. Барилга байгууламжийн угсралтын үед гарсан осол, гэмтэл хэрэглэгчийн санал гомдолын талаарх мэдээлэл:
9. Нийгмийн халамжийн хүрээнд зарцуулсан зардал /сая төгрөг/:
10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, Инженер техникийн ажилтан, нийт ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулсан байдал зарцуулсан зардал /сая төгрөг/:

№	Сургалтад хамруулсан ажилчдын тоо	Зарцуулсан зардал /сая төгрөг/

11. Шинэ дэвшилтэт материал, байгаль орчинд ээлтэй техник технологи нэвтрүүлсэн ашигласан байдал:
12. Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй эсэх:
13. ХАБЭА-д зарцуулсан зардал /сая төгрөг/:
14. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн чанарын удирдлагын тогтолцоо /нэр, дугаараар/:
15. Байгууллагын ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал:
16. Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

..... (.....)  
Тэмдэг      Гарын үсэг      Нэр

20... оны ..... сарын .....-ны өдөр

----oo0oo----